



ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ТООН ГАРЫН ҮСЭГ

ХЭЛТСИЙН ДАРГА: Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ

2022 он



Цахим хөгжлийн багц хууль буюу Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан гэрчилгээжүүлэх байгууллага гэдэг улсын бүртгэлийн байгууллага, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байна.

Улсын бүртгэлийн байгууллага Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэдэд тоон гарын үсгийн гэрчилгээг таван жилийн хугацаагаар олгоно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээг түүний оршин суух хугацаагаар эсхүл гурван жилээс дээш хугацаагаар оршин суух бол гурван жилийн хугацаатай олгоно.



“Тоон гарын үсэг” гэдэг нь цахим баримтад зурагдсан гарын үсэг бөгөөд хэвлэмэл материалд үзгээр зурсан гарын үсэгтэй ижил үүрэг, зорилготой баталгаажуулалтын нэг арга, хэлбэр бөгөөд цахим баримтад гарын үсэг зурсан этгээд хэн болохыг, тухайн цахим баримтад гарын үсэг зурагдсанаас хойш санаатай болон санамсаргүй байдлаар ямар нэгэн өөрчлөлт ороогүй гэдгийг нотлох хэрэгсэл юм.



Ямар төрлийн үйлчилгээнүүдэд түгээмэл ашигладаг вэ?

Цахим гарын үсгийг ашиглаад төрийн үйлчилгээ, банк, санхүү, даатгал, худалдааны салбар, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг маш олон салбарт үйлчилгээ үзүүлэгч аливаа байгууллагууд цахимаар харилцагчидтайгаа байгуулах дараах өгөгдлүүдийг боловсруулж, баталгаажуулж болно.

- | | |
|---------------------------------------|---|
| 01 Бүх төрлийн төрийн цахим үйлчилгээ | 04 Банк, санхүү, төлбөр тооцоо, |
| 02 Гэрээ, хэлцэл байгуулах | 05 Өрөгдөл, хүсэлт, зөвшөөрөл, албан тоот |
| 03 Даатгал, эрүүл мэндийн үйлчилгээ | 06 Бусад бүх төрлийн цахим сервисүүд |



Тоон гарын үсгийн авч ирэх үнэ цэнэ

Уг үйлчилгээ нь зөвхөн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад эдийн засгийн давуу тал авч ирэхээс гадна төр болон хувийн хэвشلүүд, байгаль орчинд дараах сайн үнэ цэнийг бүтээх юм.



01

Иргэдэд

Гэрээ хэлэлцээр байгуулах үйлдлийг гарын дор, хялбар, хурдан гүйцэтгэх боломж

03.

Бизнесүүдэд

Цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх хамгийн бодитой шийдэл болохын сацуу хуулийн хүрээнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн байна.

02.

Төрийн үйлчилгээнд

Иргэд, аж ахуй нэгжүүдэд чиглэсэн цахим төрийн үйлчилгээг шинэ түвшинд хүргэх чадамжтай болно.

04.

Байгаль орчинд

Цаасгүй хэрэглээг хамгийн өргөн хүрээнд нэвтрүүлнэ.



Тоон гарын үсгийг иргэдэд
олгосноор дараах давуу талуудыг
бий болгох юм.

- Нууцлал, аюулгүй байдал
 - Хялбар үйлчилгээ
 - Стандартад нийцтэй олон улсад шалгарсан шийдэл
- 

Давуу талууд #1

Нууцлал,
аюулгүй байдал

Хялбар
хэрэглээ

Олон улсад
хүлээн зөвшөөрөгдсөн



Аюулгүй байдал

Тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлснээрээ цахим орчинд хэрэглэгчийг таних, баталгаажуулах процесс хамгийн найдвартай хэмжээнд хүрэх бөгөөд онлайн гүйлгээ, төрийн үйлгээ гээд бүхий л цахим үйлчилгээний үеийн аливаа халдлага, хууран мэхлэлтүүдээс хамгаалагдаж юм.

Давуу талууд #2

• Нууцлал,
аюулгүй байдал

• Хялбар
хэрэглээ

• Олон улсад
хүлээн зөвшөөрөгдсөн



Хялбар хэрэглээ

Тоон гарын үсгийн тусламжтайгаар цахим орчинд хэрэглэгч, түүний төлбөр тооцоо, баримт бичгийг баталгаажуулах бүрэн бололцоотой болох бөгөөд ингэснээрээ үйлчилгээ авч буй хэрэглэгч заавал биеэр очих шаардлагагүй болж, аливаа үйлчилгээнд шинэ харилцагчаар бүртгүүлэх, гэрээ байгуулах, гүйлгээ хийх, өргөдөл, хүсэлт гаргах зэргээр онлайн үйлчилгээг илүү хүртээмжтэй, хялбараар ашиглах боломжтой болох юм.



Давуу талууд #3

Нууцлал,
аюулгүй байдал

Хялбар
хэрэглээ

Олон улсад
хүлээн зөвшөөрөгдсөн



Хүлээн зөвшөөрөгдсөн

Дэлхийн ихэнхи орнуудад тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлсэн төдийгүй банк, санхүүгийн салбар, төрийн үйлчилгээн дахь хэрэглээ дийлэнхи хэсгийг эзэлж байна. Бидний нэвтрүүлэхээр ажиллаж буй PrimeKey компанийн EJBCA Enterprise гэрчилгээ олгох үндсэн систем нь Швед, Герман, Турк, Малайз, А.Н.У, Филиппин, Арабын Нэгдсэн Эмират зэрэг томоохон улс орнуудад нэвтрүүлээд буй хамгийн найдвартай бөгөөд уян хатан систем юм.



Гэрчилгээ олгох



Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт харьяалал харгалзахгүй хандаж тоон гарын үсэг авах хүсэлтийг гаргана.

- Иргэний үнэмлэхийн хамт биечлэн ирнэ.
- Бичгээр гаргана.


Иргэн тоон гарын үсэг авах хүсэлтийг Улсын бүртгэлийн байгууллагын киоск машинд хандан цахим хэлбэрээр гаргаж болно.

Гэрчилгээ системээс үүсгэгдэж, тоон гарын үсгийн ПИН код, ПУК код, зөвлөмжийг иргэний цахим шуудан, гар утсанд илгээнэ.



Иргэнд олгосон гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Улсын бүртгэлийн байгууллага дараах тохиолдолд иргэнд олгосон гэрчилгээг түдгэлзүүлнэ:



иргэн өөрийн эзэмшиж буй гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан;

/бичгээр, цахим хэлбэрээр/



гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, эсхүл хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж Улсын бүртгэлийн байгууллага үзсэн;



хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчилгээг түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;



эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.



ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧ ДАРААХ ҮҮРЭГТЭЙ:

1. Хувийн түлхүүрийг бусдад шилжүүлэхгүй байх;
2. Хувийн түлхүүрийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;
3. Хувийн түлхүүрийг бусад этгээд мэдсэн, эсхүл мэдэх үндэслэлтэй гэж үзвэл энэ тухай гэрчилгээжүүлэх байгууллагад даруй мэдэгдэх;
4. Гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээнд хамаарах хувийн түлхүүрийг ашиглахгүй байх;
5. Хууль бус гэж үзсэн мэдээллийг баталгаажуулах, нууцлахад хувийн түлхүүрийг ашиглахгүй байх;
6. Хуульд заасан бусад.



ХАРИУЦЛАГА

1. Гэрчилгээ эзэмшигч өөрийн буруугаас болж хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задалсан, ПИН болон ПУК кодыг мартсанаас үүсэх үр дагаварыг эзэмшигч тал өөрөө хүлээнэ.


2. Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, гэрчилгээг түр түдгэлзүүлээгүйгээс үүдэн гарах аливаа хохирлыг гэрчилгээ олгогч байгууллага хариуцахгүй.

Tigrum

Ухаалаг утасны аппликэйшн

Хэрэгцээнд нийцүүлэв

Ухаалаг зөөврийн төхөөрөмжүүд дээр ашиглах аппликэйшнийг хөгжүүлснээрээ хэрэглээний боломжуудыг улам тэлж өгсөн



Ямар ч төрлийн аппликэйшнтэй хоршиж ажиллах боломжтой.

Байгууллагууд өөрсдийн интернет, цахим банкны апп уудтай интеграцлал хийн холбож өгөх боломжтой.



Олон гэрчилгээтэй ажиллах боломжтой

Хэрэглэгч өөрийн хэрэгцээнд нийцүүлэн нэгээс олон тоон гарын үсгийн гэрчилгээтэй байж болох бөгөөд энэхүү аппликэйшнийг ашиглан тохирох гэрчилгээг сонгон ашиглах боломжтой.




Нууцлалын тохиргоог сонгох боломжтой

Хэрэглэгч өөрийн гэрчилгээг баталгаажуулах PIN кодыг солих, баталгаажуулалтын үед хурууны хээ болон FaceID -г ашиглах эсэхээ өөрөө тохируулах боломжтой.

№	Сумын нэр	16-аас дээш насны нийт иргэдийн тоо	Тоон гарын үсэг авсан иргэдийн тоо	ТГҮ аваагүй иргэдийн тоо	Хамрагдалтын хувь
1	Адаацаг	1925	695	1230	36,1
2	Баянжаргалан	880	416	464	47,3
3	Говьугтаал	1108	317	791	28,6
4	Гурвансайхан	1539	427	1112	27,7
5	Дэрэн	1480	499	981	33,7
6	Дэлгэрцогт	1167	787	380	67,4
7	Дэлгэрхангай	1592	274	1318	17,2
8	Хулд	1697	707	990	41,7
9	Луус	1349	149	1200	11
10	Өлзийт	1745	256	1489	14,7
11	Өндөршил	1053	481	572	45,7

Тоон гарын үсэг олголт





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

ЭДТГ-ын байр, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48101
Утас: 70592435, Факс: (976) 70592435
Цахим шуудан: dundgovi@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.burtgel.gov.mn

2022.11.08 № 4/588

тэнцй _____-ны № _____-т

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны
явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны
жагсаалтын дагуу хадгалах хугацаа нь дууссан баримт
бичгийн жагсаалтыг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай



Байгууллагын нэр: **Дундговь аймаг дахь улсын
бүртгэлийн хэлтэс**
Газар хэлтэс: **Увирдлага**
Албан тушаал: **Хэлтсийн дарга**
Овог нэр: **Жамбал Өлзийжаргал**
Зурсан огноо: **08.11.2022 09:25**

21-р зууны манлайлын ур чадвар

2. ТЕХНИК ТЕХНОЛОГИТОЙ ХАРИЛЦАХ (TECHNICAL SKILLS)



- Технологийг үр дүнтэй ашиглах,
- Цахим орчинд үр дүнтэй ажиллах,
- Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан үр дүнтэй дүн шинжилгээ хийх

Технологийг сайн ашигладаг бол илүү үр дүнтэй, хурдтай ажиллах боломж бүрддэг. Эзэмшээд удирдаад л сурчихвал, технологи асар их ажлыг хөнгөвчлөх болно.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА